МОНГОЛ УЛС, ЗАВХАН АЙМАГ

# АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД, УЛИАСТАЙ СУМЫН ЖИНСТ БАГТ “БИЕ ДААН” НЭР ДЭВШИГЧ ХАДАНХҮҮГИЙН МИШИГБААТАРЫН 4 ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

8117144190
ИЮА8110 9039376

2020.07.18

**МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

## УРИА: ЗАВХАНЫ ХӨГЖИЛ- НОГООН ИРЭЭДҮЙ

| Зорилт | Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа |
|---|---|
| **1.**Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх. | 1.1. Иргэдийг жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах, Эрүүл мэндийн даатгалын албатай хамтран ажиллаж, төрөөс үзүүлж буй дэмжлэгт бүрэн хамруулна.<br>1.2. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн чадавхыг бэхжүүлж, эмч, мэргэжилтний ур чадварыг дээшлүүлнэ.<br>1.3. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн зүрх судасны кабинетын үйл ажиллагааг өргөжүүлж, “Баруун бүсийн тэргүүлэх” чиглэл болгон хөгжүүлнэ.<br>1.4. Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах чиглэлд олон улсын төсөл хөтөлбөрийн дэмжлэгийг авч хамтран ажиллана.<br>1.5. Нийгмийн эрүүл мэндийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлж, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл, амьдралын дадлыг хэвшүүлэхэд оновчтой арга хэлбэрийг хэрэгжүүлнэ. |
| **2.** "Завханы хөгжил-ногоон ирээдүй" хөтөлбөр хэрэгжүүлэх | 2.1. Эко –хүүхэд, залуучууд клуб ажиллуулна.<br>2.2. Иргэдийн оролцоотойгоор сум хөгжүүлэх эко шинэ санаачилгыг нэвтрүүлж ажиллана.<br>**2.3.** Ногоон байгууламж, эко гэр бүл, хамт олон шалгаруулж |

| | |
|---|---|
| | урамшуулна.<br>2.4. Байгаль, орчинд ноцтой хохирол учруулах хууль бус үйлдэлтэй тэмцэх, хуулийн сургалт, сурталчилгааг зохион байгуулж иргэдэд зөв дадал хандлагыг төлөвшүүлнэ. |
| **3.** Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх. | 3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, залуучуудыг ажлын байраар хангахад төрийн болон олон улсын хөтөлбөр төслийн байгууллагуудтай хамтран ажиллана.<br>3.2. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ санаа, оновчтой ажлын туршлагыг нэвтрүүлнэ.<br>**3.3.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинжилгээ, судалгааг хийж, төрийн бодлогод тусгуулна. |
| **4.** Иргэнээ дээдэлсэн, шударга, ёс зүйтэй төрийн албатай байх. | 4.1. Иргэдээ сонсдог байх, иргэдэд нээлттэй, ил тод "Иргэн төвтэй төрийн үйлчилгээ"-г нэвтрүүлэхэд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллана.<br>4.2. Төрийн мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн данс, авлига, төсвийн, сангуудын мэдээллийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр мэдээлдэг цахим санг хэрэгжүүлнэ.<br>4.3. Сайн засаглалыг бэхжүүлэхэд иргэдийн дуу хоолой болж, иргэдээ төлөөлөн ажиллана. |

8117144190
ИЮА0110 9039376

....................о............................